



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/331

Улаанбаатар хот

Аргачлалд нэмэлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн найруулж баталсантай холбогдуулж Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны "Аргачлал батлах тухай" А-117 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2.3 дугаар хэсэгт дор дурдсан нэмэлтийг оруулсугай.

Шинжээч нь дараах нөхцөл, шаардлагад нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн төсөлд үнэлгээ хийнэ.


1.1. Аюултай болон энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулсан эсэх;

1.2. Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор эрчим хүчний шийдлийг байгальд ээлтэй технологи ашиглаж халаалт, дулааны асуудлыг шийдвэрлэх боломжийг төсөлд тусгасан эсэх;

1.3. Байгаль орчинд халгүй, хөрсний бохирдол үүсгэдэггүй ариун цэврийн байгууламж байгуулах, төслийн цар хүрээнээс хамааран бага оврын цэвэрлэх байгууламжтай байх талаар төсөлд тусгасан эсэх;

2. Дээрх оруулсан нэмэлт, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга, Ерөнхий шинжээч Г.Нямдаваа, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга А.Энхбат нарт үүрэг болгосугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ